

“Дархан брокер” ХХК-д брокер, дилерийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 болон 15.3.5 дахь заалтууд, “Дархан брокер” ХХК-иас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Дархан брокер” ХХК-д үнэт цаасны зах зээл дээр брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2.Хөрөнгө оруулагчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг Компанийн гүйцэтгэх захирал /Ж.Очирсүх/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд сурталчлан ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ